



<https://publications.dainst.org>

iDAI.publications

DIGITALE PUBLIKATIONEN DES
DEUTSCHEN ARCHÄOLOGISCHEN INSTITUTS

Das ist eine digitale Ausgabe von / This is a digital edition of

Franken, Christina

Die „Grosse Halle“ von Karakorum: zur archäologischen Untersuchung des ersten buddhistischen Tempels der alten mongolischen Hauptstadt

der Reihe / of the series

Forschungen zur Archäologie außereuropäischer Kulturen; Bd. 12

DOI: <https://doi.org/10.34780/coic-cbqc>

Herausgebende Institution / Publisher:
Deutsches Archäologisches Institut

Copyright (Digital Edition) © 2022 Deutsches Archäologisches Institut
Deutsches Archäologisches Institut, Zentrale, Podbielskiallee 69–71, 14195 Berlin, Tel: +49 30 187711-0
Email: info@dainst.de | Web: <https://www.dainst.org>

Nutzungsbedingungen: Mit dem Herunterladen erkennen Sie die Nutzungsbedingungen (<https://publications.dainst.org/terms-of-use>) von iDAI.publications an. Sofern in dem Dokument nichts anderes ausdrücklich vermerkt ist, gelten folgende Nutzungsbedingungen: Die Nutzung der Inhalte ist ausschließlich privaten Nutzerinnen / Nutzern für den eigenen wissenschaftlichen und sonstigen privaten Gebrauch gestattet. Sämtliche Texte, Bilder und sonstige Inhalte in diesem Dokument unterliegen dem Schutz des Urheberrechts gemäß dem Urheberrechtsgesetz der Bundesrepublik Deutschland. Die Inhalte können von Ihnen nur dann genutzt und vervielfältigt werden, wenn Ihnen dies im Einzelfall durch den Rechteinhaber oder die Schrankenregelungen des Urheberrechts gestattet ist. Jede Art der Nutzung zu gewerblichen Zwecken ist untersagt. Zu den Möglichkeiten einer Lizenzierung von Nutzungsrechten wenden Sie sich bitte direkt an die verantwortlichen Herausgeberinnen/Herausgeber der entsprechenden Publikationsorgane oder an die Online-Redaktion des Deutschen Archäologischen Instituts (info@dainst.de). Etwaige davon abweichende Lizenzbedingungen sind im Abbildungsnachweis vermerkt.

Terms of use: By downloading you accept the terms of use (<https://publications.dainst.org/terms-of-use>) of iDAI.publications. Unless otherwise stated in the document, the following terms of use are applicable: All materials including texts, articles, images and other content contained in this document are subject to the German copyright. The contents are for personal use only and may only be reproduced or made accessible to third parties if you have gained permission from the copyright owner. Any form of commercial use is expressly prohibited. When seeking the granting of licenses of use or permission to reproduce any kind of material please contact the responsible editors of the publications or contact the Deutsches Archäologisches Institut (info@dainst.de). Any deviating terms of use are indicated in the credits.

17 Хархорумын “Их танхим”-ын олдворын цогц байдал. Ордны дүүрэг хэмээх цогцолборт хийсэн малтлага шинжилгээ – Товч агуулга

Толилуулан буй бүтээлд Хархорумын “Их танхим”-ын хэсэгт Монгол-Германы Хархорум Экспедицийн 2000–2006 онд явуулсан шинжилгээний үр дүнг нийтэлж байна. Эхний бүлгүүдэд түүхэн учир шалтгаан ба судалгааны тоймыг өгүүлэв. Үүний дараа олдворын цогц байдал бүрийг нарийвчлан тодорхойлж ижил төстэй дурсгалуудтай харьцуулан судалсны эцэст энд буддын шашны их сүмийн байгууламжтай холбоотой барилгын цогцолбор байсан хэмээх дүгнэлтэнд хүрлээ.

Янз бүрийн нөхцөл байдал хийгээд бодол санааны үүднээс бичсэн түүхийн өөр өөр эх сурвалжуудаас бид Монголын нийслэл Хархорумын түүх ба хөгжлийн тухай ойлголт төсөөллийг авч байна. Элчин харилцааны зэрэгцээ ихэвчлэн өөрсдийн шашин суртлаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор дорно дахинд зорчиж байсан европ санваартнуудын аян замын тэмдэглэлээс гадна монгол гаралтай цөөн тооны анхдагч хоёрдогч сурвалжууд буй. Үүний дотроос францискан ёсны санваартан Иоханнес фон Плано Карпини хийгээд Вильхельм фон Рубрук нарын тэмдэглэл онцгой ач холбогдолтой юм. Ялангуяа Рубрук бол Мөнх хааны ордонд удаан хугацаагаар сууж, төрөлх нутагтаа буцаж ирсэн хойноо Монголын нийслэл хотын амьдралын тухай хамгийн амьдлаг бөгөөд нарийвчилсан тодорхойлолтыг бичиж үлдээсэн билээ. Түүнчлэн персийн түүхч Ата-Малик Жүвэйни, Рашид-ад-дин, Аль-Умари нар өөрсдийн туурвисан түүх цадигтаа Хархорумын тухай өгүүлсэн байдаг. Үүний хамт Юань гүрний албан ёсны түүх болох Юань-ши бол хотын түүхийг судлах чухал сурвалжийн нэг боловч үнэн хэрэгтээ харьцангуй хожуу цаг үед бичигдсэн юм. Хархорумд барьж байгуулсан барилга байгууламжуудын тухай тодорхой заалтыг 1346 оны нэгэн бичээс өгч байдаг. Хархорумаас хагархай хэсгүүд нь илэрч олдсон хоёр хэлээрх энэхүү бичээст “Юань улсыг мандуулах асар”-ыг барьж байгуулсан үйл явдлын тухай өгүүлжээ. Ялангуяа энэхүү сурвалжид тэмдэглэн бичсэн барилгын чуулбарын тухай тодорхойлолт бид-

ний малтлага судалгаагаар илрүүлсэн олдворын цогц байдалтай олон зүйлээрээ тохирч байгаа нь үзгэл илэрхий бөгөөд сонирхолтой байна.

Хархорум дахь дундад эртний хотын байгууламжийн баруун өмнөд хэсэгт орших “Их танхим” хэмээн нэрлэж буй дэвсгэр газар 1933 онд орос археологич Дмитрий Демьянович Букинич анх удаа малтлага хийжээ. Тэрбээр малтлагынхаа үр дүнд тулгуурлан энд байсан барилгын чуулбарыг тайлбарлахдаа хааны ордон биш, харин буддын шашны ямар нэгэн сүм хийдийн барилга байсан гэж дүгнэсэн анхны судлаач болох юм. Гэтэл Хархорум ба “Их танхим”-ын хэсгийг 1948–1949 онд анх удаа их хэмжээгээр малтан шинжилсэн Оросын археологич Сергей Владимирович Киселев урьд өмнөх судалгааны энэхүү санаа дүгнэлтийг үл ойшоож энэ газар Хархорум хотод сууж байсан монгол хаадын ордон байсан гэдэг үзэл баримтлалыг дэвшүүлэн тавьжээ. Монголын тал ч гэсэн Хархорумын шинжилгээ ба хотын баруун өмнөд дүүрэгт орших чухам ямар үүрэг зориулалттай газар байсан нь маргаантай дэвсгэр нутгийн судалгааг урагшлуулахад хувь нэмрээ оруулсан юм. 1970–аад оны сүүлчээр энд Монголын археологич Намсрайн Сэр-Оджав судалгаа хийсэн боловч малтлагын үр дүн нь одоо болтол хэвлэн нийтлэгдээгүй байна.

“Их танхим” болон түүний баруун талын барилгыг 2000–2006 онд Германы Археологийн Хүрээлэнгийн Европын бус Соёлын Археологийн Комисс бүх талбайгаар нь малтаж гаргасан билээ. “Их танхим”-ын үлдэгдлийг дотоод гадаадын аялагч жуулчдад үзүүлэх ил үзмэр болгон эзэмших зорилгын хүрээнд археологийн дараагийн шатны ажлууд хийх шаардлага тулгарав. Ингээд 2013–2014 онд явуулсан судалгаагаар тухайн газрын үүрэг зориулалтыг тайлбарлахад үлэмж ач холбогдолтой шинэ мэдлэг олгосон олдворын цогц байдлыг нээн илрүүлсэн боловч толилуулан буй бүтээлд зөвхөн ерөнхийд нь дүгнэх байдлаар оруулсан болно. Энэ тухай цаашид улам нарийвчлан судалж нийтлэхээр зэхэж байна. Археологийн ажлын үеэр дотоод

засал төлөвлөлт ба олдвор хэрэглэгдэхүүнийхээ бүхий л чуулбарын хувьд буддын шашны сүм байсан гэж сая нэг итгэл төгс хэлж болохоор, шороо үелүүлэн дэлдэж хийсэн суурин дээр байгуулсан танхимын үлдэгдлийг малтаж гаргасан нь барьж байгуулсан арга хийгээд уран барилгын онцлогийн хувьд дараах байдалтай байлаа.

Олдворын цогц байдлын шинжилгээг дүгнэж үзэхэд, шороо үелүүлэн дэлдэж хийсэн хоёр метр орчим өндөр хиймэл довжоон дээр байгуулсан хааш хаашаа 38x38 м орчим урт, төв суурь нь тэг дөрвөлжин хэлбэртэй барилга байсан нь тогтоогдлоо. Барилгын суурийг бат бөх болгож, бас гоё сайхан харагдуулахын тулд довжооны нүүрэн талыг ихэвчлэн босоо талын ирмэгээр нь давхарлаж өрсөн туйпуугаар хийсэн 1,60–1,80 м өндөр ханаар өнгөлсөн байжээ. Нүүрэн талыг өнгөлсөн энэхүү ханын булангийн зохион байгуулалт нь босоо байрлалтай боржин чулуун тулгууруудаас бүрдэнэ. Суурийн дөрвөн булангийн дороос болон довжоон дээр баруун, зүүн талаас нь гардаг шатны дороос тус бүр суурийг дэлдэх үед тэнд аравнайж тавьсан шүншиг олдво. Сүмийн шүншигт тариа будаа, төрөл бүрийн жимс, торгонд боодолтой “есөн эрдэнэ” орсон бөгөөд том вааран саванд хийж амсрыг нь шавар тагаар таглаж тавьжээ. Есөн төрлийн материалаас бүрдсэн эд юмс нь бүтээн цогцолсон суварга шүтээнийг амилуулан тэтгэх нарийн нандин бэлгэтэй аж.

Энэхүү довжоон дээрхи боржин чулуун тулгууртай 8 x 8 баганатай буюу долоон жангийн барилгын доторхи багана хоорондын зай нь ханын хэсгүүдийн зохион байгуулалтаас шалтгаалан харилцан адилгүй хэмжээтэй байжээ. Баруунаас зүүнш, тэрчлэн хойноос урагш харсан хоёр дахь, дөрөв дэх, зургаа дах таславч нь нэг, гурав, тав дахиасаа өргөн аж.

Ханын хэсгийн үлдэгдлүүд бүхэлдээ зөвхөн хэсэг бусаг байдлаар олдсон бөгөөд хойд, баруун, зүүн талын хамгийн гаднах эгнээний баганын сууриудын дотоод ирмэгийн дагуу үргэлжилсэн хоёр болон зургаа дахь таславч буюу жангийн орчим байсан өргөргийн дагуу чиглэлтэй гадна талын ханынх гэж төсөөлж болохуйц байлаа. Харин барилгын дотор талын зүүн баруун чиглэлтэй ханын хэсгүүдээс юу ч үлдсэнгүй.

Барилгын оршиж буй төвшин нь орон нутгийн хэсэг газрын 100,00 метрийн өндөрлөгт байрлах бөгөөд шал нь захаараа саарал өнгөтэй, паалангүй, харин төв хэсэгтээ тэг дөрвөлжин, ногоон паалантай хавтангуудыг доор нь саарал өнгөтэй шавар зуурмаг түрхэж үүн дээр дэвсэж хийсэн зохион байгуулалттай болох нь барил-

гын дотор талд бүхэлдээ мэдэгдэж байлаа. Барилгын хөвөөгөөр зэргэцүүлэн дэвссэн шалны эдгээр хавтанг эс тооцвол гонзгой дөрвөлжин хэлбэртэй саарал өнгийн хавтангуудыг барилгын дөрвөн булангаас төв гол хэсэг рүү чиглэсэн хошуулдсан чиглэлээр дэвссэн ажээ. Өөрөөр хэлбэл, саарал өнгөтэй эдгээр хавтангаар барилгын төв гол руу аваачих дөрвөн замыг шалласан байна. Энэхүү хошуулдсан замын ам болгон дээр бадма сэнтийтэй гуутай бурхадын дүрс байсны үлдэгдэл баруун хойд болон зүүн хойд хэсэгт хадгалагдаж үлдсэн байна. Эндээс үзэхэд хошуулдсан дөрвөн замын аманд, бүгдээрэнд нь иймэрхүү дүрсүүдийг залж байсан гэж дүгнэж болохоор байгаа юм.

Барилгын төв хэсгээс шалны төвшин дотроос олдсон 22 x 22 м хэмжээтэй томоохон орон зайн гол дундаас тал бүр нь 2,80 м орчим хэмжээтэй дөрвөлжлөн өрсөн хашлага илэрч түүний төв хэсгээс олон үе дагтаршуулан дэлдсэн суурийг доош нь ухаж хийсэн дарш олдво. Зориуд санаатай тавьсан энэхүү зүйл нь магадгүй барилгын суурийг дэлдэх үед аравнайлан тавьсан шүншиг бололтой.

Төв хашлагын эргэн тойронгоос бүдүүн ширхэгтэй түүхий шавраар хийсэн арван мянган цацнаас бүрдсэн дөрвөн томоохон бөөгнөрөл олдсон. Бөөгнүүлэн тавьсан цацны яг гадна талыг хүрээлэн уртааш нь босгож дөрөв хүртэлх эгнээгээр давхарлан өрсөн таван эгнээ өргөн тоосгон байгууламжийн үлдэгдэл илрэв. Цацны бөөгнөрлийн гаднах дөрвөн тал болгонд ийм зүйл байсан гэдгийг нотолж болохоор байсны зэрэгцээ тэр хэсэг газар шал байхгүйгээс үзэхэд барилгын энэхүү гол зохион байгуулалт нь хэдийгээр олдворын цогцолборын хадгалагдсан нөхцөл байдлаасаа болж жинхэнэ өндрийг мэдэх боломжгүй болсон хэдий ч тавцан маягийн хучаас юмуу, эсвэл барилгын голд давхарлан барьсан байгууламжтай холбоотой байсан гэж дүгнэж болохоор байв. Энд ямар нэгэн суварга байсан гэж үзэх магадлал хамгийн их байна.

Танхимын дээвэр нурууг чулуун суурин дээр босгосон модон баганууд тулж байсан бөгөөд дээврийн хэсэг нь нэг юмуу хэд хэдэн давхраас бүрдэж байсан бололтой. Нурж унасан байдалтай олдсон шургааг болон банз модны үлдэгдлээс үзэхэд модон хийц голлож байсан нь илэрхий агаад паалантай тоосго асар ихээр олдсон нь уг барилга вааран тоосгоор хучсан гоёмсог дээвэртэй байсныг гэрчилнэ.

Тавцан суурийн баруун болон зүүн талд голлуулан хийсэн, орон нутгийн тухайн хэсэг газрын 98,20 метр өндөрт байрлах шатаар довжоон дээр гардаг байв. Хойд талын барилгатай холбогдсон хүзүүвч маягийн зохион байгуулалт

нь хоймор хэсэгтээ хоёр хажуу руугаа гарч ордог шаттай байсан бөгөөд эдгээр нь их танхимын хойд хаалганы үүргийг гүйцэтгэж байжээ. Үүнээс гадна уг хаалгаар гол барилгын хойд талд буй хүзүүвчээр дамжин мөн хиймэл тавцан дээр байгуулсан жижиг барилга руу орж гардаг байсан бололтой. Харин гол барилгын урд талын хэсгийн хувьд гэвэл, энэ газар урьд өмнөх малтлагуудаар нэлээд хөндөгдөж эвдэгдсэн тул өмнөд хаалга ямаршуу байдалтай байсан тухай зөвхөн таамаглал дэвшүүлэх л боломжтой. Гэвч энд бас шат байсан гэдгийг одоо болтол хадгалагдаж үлдсэн өгсүүр тавцан харуулж байна. Эдгээр шатны байдлаас үзэхэд уг барилга дөрвөн талдаа тус бүр хаалга үүдтэй байсан байж таарч байна. Дэвсгэр зургаас харахад өмнөд хаалга нь баруун, зүүн талынхыгаа бодвол илүү нүнжигтэй чимэглэгдсэн бөгөөд үүдний хэсэгтээ дээвэртэй байсан нь түүнийг тулж байсан хэд хэдэн багана буйгаас мэдэгдэнэ. Тэрчлэн барилгын суурийн өмнөд хэсэг хийгээд бас дээр нь юм бариагүй хэсгүүдэд ч гэсэн шавар зуурмаган дээр дарагдан үлдсэн ормоос үзэхэд уг барилгын гадна талыг суурийн нь нэгэн адил тэг дөрвөлжин хэлбэртэй, саарал өнгийн шатаасан тоосгоор бүхэлд нь шаллаж байсан бололтой байна.

Барилгын ажилд хэрэглэсэн түүхий эд болон арга маягаас ерөнхийдөө хятад маягийн загвараар яс модыг нь зангидаж барьсан танхим байсан гэж таамаглаж болох юм. Тэрчлэн нуранги дотроос гарсан ногоон, улаан өнгийн паалантай дээврийн ваар, зарим газраа будагтай модны үлдэгдэл зэрэг нь зохион байгуулалт, засал чимэглэлийн хувьд хятад маягийн загвараар төлөвлөж хийсэн дээвэртэй байсныг харуулж байна. Барилгын дээврийн нүүр ваарыг ангиалан үзэхэд олон хийц бүтцээс бүрдсэн дээвэртэй байсан нь мэдэгдэнэ. Дээврийн ваарны ихэнхи нь ногоон паалантай байх бөгөөд хааяа улаан юмуу шар өнгийн паалантай үлдэгдлүүд тохиолдоно. Модон хийц ба дээврийг өнгө алаглуулан засаж чимэглэх нь хятад төдийгүй төвдийн уран барилгад ч гэсэн онцгой үүрэг гүйцэтгэж байсан нь тодорхой бөгөөд өнгө будгаар дамжуулан тухайн барилгын зэрэг зиндаа хийгээд үйл ажиллагааных нь утга холбогдолыг улам тодотгож өгдөг.

Их танхимын барилгын хийц бүтцийн тун өчүүхэн бага хэсэг л хадгалагдаж үлдсэн болохоор түүнийг сэргээн төсөөлөхийн тулд харьцуулан үзэж болохоор ижил төстэй дурсгалууд хийгээд уран барилгын нөлөөллийн жишээ хэрэгтэй юм. Дундад зууны Монгол дахь нүүдэлчдийн нийгмийн уран барилгын хөгжил маш өвөрмөц байсан учраас энэхүү нөлөөллийг

тухайн орон нутгаас хайхаас илүүтэйгээр, энэ бүхнийг авчирч хэрэгжүүлсэн хөрш зэргэлдээх бүс нутаг Хятад, Төвд оронд эрж үзэх нь зохистой байна.

Монголтой харьцуулахад энэ хоёр орон 13 дугаар зууны эхэн гэхэд зуу зуун жилийн, Хятадад бол тэр ч байтугай бараг мянган жилийн уран барилгын баялаг уламжлалтай байлаа. Нүүдэллэн аж төрдөг монголчуудын хувьд өмнө нь зөвхөн доогуур зэргийн ач холбогдолтой байсан уран барилгын хэлбэрүүдийн төсөөллөө хөгжүүлэхийн тухайтад монгол хаад Хятад оронтой идэвхитэй харилцаж байсан хэдий ч бас төвдийн эрдэмтэн чадвартануудыг ашиглаж байсан хэмээн үзэж болно.

Хятад болон Төвдийн уран барилгын хөгжлийг харьцуулан ажиглахад Хархорумын “Их Танхим” хэмээх барилгыг үндсэн зарчмын хувьд хятад загвараар төлөвлөж барьсан боловч түүний орон зайн засал чимэглэл нь үнэн хэрэгтээ төвдийн шашны ертөнцийг үзэх үзлийн дагуу төлөвлөгдсөн бүрдэл хэсгүүдийг илэрхий агуулж байна.

Юуны өмнө хятадын уран барилгын хэвшмэл элементүүд болох барилгын суурийн хэлбэр, модоор яс мод зангидаж хийх арга, гоёж чимэглэсэн дээвэр зэргээр “Их танхим” нь хятад загвараар төлөвлөгдөж баригдсан барилга болохыг мэдэж болно. Шороо үелүүлэн дэлдэж хийсэн суурийн тавцанг тоосгоор өнгөлж хана байгуулсан байгууламж олдворын цогц байдалаас тодорхой мэдэгдэж байсны нэгэн адил барилгын модон баганыг зүгээр шалан дээр биш, харин доор нь чулуун суурь ивж босгох явдал Хан улсын үеэс түгээмэл болжээ. Эдгээр нь дээврийн хийцийн модны нурж унасан үлдэгдлийн хамт үргэлж гарч ирэх бөгөөд магадгүй *Tailiang* гэж нэрлэж байсан, модоор яс мод зангидаж хийдэг уран барилгын бүтцийн үндсэн элемент бололтой. Уг нэр томъёогоор багана, дүнз, даацын тулгуур хэрэглэсэн зохион байгуулалтыг илэрхийлдэг.

“Их танхим”-ын дээврийн гоёл чимэглэлийн зориулалттай засал чимэглэлийг их хэмжээгээр хадгалагдан үлдсэн дээврийн паалантай гоёмсог ваарнууд тодорхой гэрчилнэ. Тэдгээрийн нурж унасан байдлаас хавтгай дээвэр биш байсан гэдгийг мэдэж болно. Барилгын зах хөвөө хэсгийн олдворын цогц байдлаас үзэхэд дээврийн ваарны цул нурангийн дундаас нүүр хэсгийн чимэглэлтэй зурвас байсан нь илэрхий мэдэгдэх бөгөөд барилгын дээвэр нурах үед ваарнууд дээврийн булангийн тэнгэр өөд тэмүүлсэн хэсгийн хоорондох нам тал руугаа гулсаж унасан байдалтай байдаг. Гэтэл төвд загварын хавтгай дээврийг ваарладаггүй билээ.

Ийнхүү тус барилгыг барьж байгуулахдаа хятадын уран барилгын үндсэн зарчмуудыг ашигласан бөгөөд түүний засал чимэглэлийн нарийн хэсгүүд нь ямар байсан тухай зөвхөн таамаглал дэвшүүлэх төдий л хариулт өгч болох юм. Энэ нь юуны өмнө барилга яг хэдий хэр өндөр байсан, дээврийг нь яаж чимэглэж байсан, хэдэн давхарлигаас бүрдэж байсан, дотоод засал чимэглэл нь ямаршуу дүр төрхтэй байсан зэрэг асуудалд хамаарна. Модон багануудын хадгалагдсан өндөр хийгээд тойргийн хэмжээнээс өндрийг нь багцаагаар олж болох бөгөөд Гучов, Брант нарын хэлснээр 0,5–0,6 м голчтой багана нь хамгийн ихдээ 35 м өндөр байх боломжтой гэсэн тооцоо байдаг ажээ. Барилгын нурангийн үе давхрагын дотор есөн метр орчим урт нэгэн баганын үлдэгдэл нурж унасан байдалтай олдсоноос үзэхэд археологийн олдворын цогц байдалд үндэслэн тус барилгын дээврийн нүүр ваараар чимэглэсэн эхний бүтэц хүртэл дор хаяж есөн метр өндөр байжээ хэмээн төсөөлж болох юм.

Дээврийн нүүр ваарнуудын хэв маяг, хуваарилалтаар дамжуулан ямартай ч гэсэн уг барилгын дээврийн чимэглэл ямар байсан тухай тайлбарлах эхний оролдлого хийж болох байна. Нурангин дотроос дээврийн ваарны олон янзын бөөгнөрөл илэрсэн нь хэрэв энэхүү тайлбарыг дагахыг хүсвэл, магадгүй хоёроос гурван давхарлигаас бүрдсэн дээвэртэй байсныг харуулах бөгөөд чингэж үзвэл хоёроос гурван давхар байгууламж буюу давхарлиг дээвэртэй асар байсан гэж төсөөлж болно. Дээврийн олон хэсэг бүхий хийц бүтцээс үл хамааран ногоон паалантай дээврийн ваар их хэмжээгээр олдсон, улаан өнгөтэй тоосго ганц нэг гарсанаас бодож үзэхэд барилгын дээврийн чимэглэлд ноёлж байсан өнгийг мэдэж болох юм. Тэрчлэн янз бүрийн дүрстэй тоосгон чимэглэлийн үлдэгдэл олдсон нь хятад уран барилгын дээврийн нуруу ба түүний дээд ирмэгийг чимэглэдэг хэвшмэл зүйлс билээ.

Хадгалагдаж үлдсэн багана нь дор хаяж есөн метр өндөр байгаа болон дээвэр нь олон давхарлиг асартай байсан гэж бодоход уг барилга нь бүхэлдээ гайхмаар өндөр байсныг төсөөлж болно. Өндөр асар барих уламжлалын тухайд олон даяар алдаршсан жишээ Хятадад олон бий. Тухайлбал, Фужиан мужийн Куанжоу дахь Кай Юань сүмийн 48 м өндөр тоосгон асар, Шаньси мужийн Инг тойргийн Фо Гонг сүмийн модон суваргыг дурдаж болно.

Ихэнхи хэсгийг нь модоор барьсан, ийм өндөр барилгын нурангиас илүү их зүйлийг хүлээж байсан хэдий ч барилгын шалан дээгүүр байгаа нурангийн хэмжээ харьцангуй бага

байлаа. Барилга бүхэлдээ хүчтэй гал түймэрт өртөж нурж унасан хэдий ч эндээс дахин хэрэглэж болох барилгын материалуудыг хожим өөр зорилгоор зөөж ашигласан тул 21 дүгээр зууны эхэн хүртэл хадгалагдаж үлдсэн материал нь тоо хэмжээний хувьд төдийлөн утга төгөлдөр байж чадсангүй.

Барилгын гадна талын засал чимэглэл, барьж байгуулсан арга маягт нь хятад уран барилгын онцлогтой шинж тэмдэг нэлээд үзэгдэхийн зэрэгцээ юуны өмнө үндсэн засал чимэглэл болон барилгын үүрэг зориулалтыг илэрхийлэхэд төвдийн нөлөө байгааг дараах зүйлээс харж болно.

Энэтхэгийн соёл иргэншлийн хүрээнээс гаралтай Төвдийн буддын шашны уран барилгад ихээхэн ач холбогдолтой хүчин зүйлийн нэг бол орчлон ертөнцийн зүг чигийг чанд баримтлах явдал юм. Энэ нь шүтээний барилга байгууламжийг барихад хоёр хэмжээст дэвсгэр зурагт болон гурван хэмжээст зураг төлөвлөлтөн дээр ч илэрдэг. Ялангуяа 11 дүгээр зууны үеэс буюу шашин ном дэлгэрсэн хожуу үеийн эрин зуунд, барилга барихад бэлгэдэлийн утгаар суурийг нь мандалагийн дүрсээр үндэс болгох явдал улам бүр дэлгэр болж байсны сонгодог жишээ нь Төвдийн Самье хийд болно. Мандалын үндсэн бүрдэл хэсэг болгож тэг дөрвөлжин ордоны төв дунд сэнтийдээ заларсан гол их бурханыг залах бөгөөд түүний дөрвөн зүгт дагалдах бусад бурхадыг хүрээлүүлэн залдаг. Эдгээр нь бие, хэл, сэтгэлийн орчлонг ариусган амирлуулахын утга учиртай. Бурхадын гол тайлбар нь төвдийн уламжлалаар орчлон ертөнцийн төв хэмээн үздэг ертөнцийн уул болох Мэрутэй холбоотой байдаг. Иймээс мандала хэлбэрийн ордоны хэсгүүд нь төв голынхоо хамт дэлхий дахиныг ертөнцийн дөрвөн зүгт хуваасан таван хэсгийг бэлгэдсэн байх бөгөөд хүний сэтгэхүйд язгуурын таван бурханы дүрслэлээр буудаг. Орчлон ертөнцийн дэг журмын тухай энэхүү үзэл санааны уран барилга дахь хамгийн ойрын биежсэн төлөөлөл бол суварга юм.

Барилгын үүрэг зориулалтын тухайд хятад маягийн барилгын арга техникийн задаргаа илт дутагдаж байхын зэрэгцээ, илэрч буй яс мод зангидаж хийсэн бүтэцтэй барилгын системийн нийтлэг хэрэглээг үндэслэн Хархорумын ганцхан Их танхимын жишээн дээр дэвсгэр зургаас харагдаж байгаа баганы сууриудын эрэмбэ дараалалын ажиглалтад үндэслэн байшингийн үүрэг зориулалтыг эхний оролдлогоор гарцаагүй тодорхойлно гэдэг амаргүй хэрэг. Ганцхан уран барилгын хэв загварыг үндэслэн шашны эсвэл иргэний барилга байсан гэж хэлэх боломжгүй. Мандалын хэлбэрийг дууриалгах,

шүтээн суварга босгох зэрэг төвд уран барилгын шийдвэрлэх бүрдэл хэсгүүдийг ажиглан судалснаар сая уг барилгыг сүмийн зорилгоор ашиглаж байсан шинж тэмдгийг таньж мэдсэн болно.

Үүрэг зориулалтын хувьд тодорхойгүй дэвсгэр зургийн хэлбэр нь харин Хархорумын судалгааны явцад тус барилгын зориулалтыг өөр өөрөөр тайлбарлах нэгэн шалтгаан болж байсан билээ. Гэсэн хэдий ч малтлага судалгааны үр дүнг нарийвчлан шинжилж барилгын дотоод засал чимэглэлийн бүрдэл хэсгүүд ба олдворуудыг харгалзан үзсэний эцэст үүрэг зориулалтыг нь итгэл төгс тодорхойлж чадахаар болов. Их танхимыг бүрэн хэмжээгээр малтаж гаргасны эцэст илрэн гарсан олдворын цогц байдлын зураглал нь ерөөс уг барилгыг барихдаа бүр эхнээсээ л сүмийн зориулалтаар төлөвлөж барьсан гэж үзэхээр баталгаатай тайлбар хийх боломжоор хангаж өгсөн юм.

Энэхүү тайлбарыг хийх болсон хэнд ч анзаарагдам баримт нотолгоо бол малтлагаас бурханы шашны холбогдолтой олдворууд асар олон тоогоор илрэн гарсан явдал гэж үзэж болох бөгөөд бүр хээрийн шинжилгээний үед энэ байдал илэрхий мэдэгдэж байлаа. Бүртгэн баримтжуулж авсан 17000 гаруй олдворын гуравны хоёроос илүү хувь нь буддын шашны холбогдолтой олдворууд болох нь тодорхой байгаа юм. Ханын чимэглэл ба буддын дүрс баримлын үлдэгдлүүд, асар олон тоогоор илэрч олдсон цац зэрэг нь хадаас мэтийн төмрийн хэсгүүдийн нэгэн адил олдворын томоохон бүлгийг үүсгэж байна. Жижиг олдворуудаас гадна бас үлэмжхэн тооны олдворын цогц байдал нь үзгэл илтэд бурханы шашны шинж тэмдгийг илэрхийлж байв. Дөрвөлжин хавтангуудыг дэвсэж хийсэн, буддын шашны свастика болон жанцан мэт бэлгэ тэмдэг бүхий хошуулдсан хавтан замын шалны орчим хадгалагдаж үлдсэн хоёр бадма сэнтий, цацны бөөгнөрөл зэрэг барилгын олон янзын онцгой содон бүрдэл хэсгүүд нь бурханы шашинтай холбоо бүхий утга агуулгатай байна. Юуны өмнө барилгын байгууламж дахь шинж тэмдгүүдийг барилгын дэвсгэр зураг дээр ажиглан харахад төвдийн ертөнцийн загварын уран барилга дахь илэрхийлэл болсон мандалагийн хэлбэртэй яруу тодоор зохицон нийцэж байгаа нь анзаарагдаж байлаа. Тэгэхлээр Хархорумын “Их танхим” нь орчлон ертөнцийн тухай энэхүү үзэл төсөөллийг дүрслэн үзүүлсэн бас нэгэн тусгал байсан болж таарч байна. Барилгын байгууламжийн тэг дөрвөлжин суурийн хэлбэр, шалны хэсэг дэх тэг дөрвөлжин хэлбэртэй орон зай, арван мянган цацны бөөгнөрөл ба энэ хэсгийн

гол төвд байгаа хүрээ хашлага зэрэг өөр бусад бүрдэл хэсгүүд нь хот мандалын тухай уран барилгын онолтой тохирч байгаа юм. Үүнээс гадна шалан дахь эргэн тойрон хашлага өрлөгөөр хүрээлэгдсэн төвийн энэхүү орон зай нь нэгэн том суварганы суурь байсан байх магадлалтай. Ийшээ очдог хошуулдсан дөрвөн замаар танхим ижилхэн хэмжээтэй дөрвөн хэсэгт хуваагдах бөгөөд эдгээрийг шаллаж байсан шинж тэмдэг мэдэгддэг. Тэр газарт бадма сэнтийтэй дөрвөн дүрсийг залж байсан бололтой. Шалны хавтангууд өөр өөр өнгөтэй байгаа нь төвийн ойр орчим газрыг дотоод болон гаднах хэсэгт зааглан хувааж байжээ.

Тэгэхдээ голын хэсгийн шалан дээр ямар ч хавтан дэвсээгүй ба арван мянган цацны бөөгнөрөл энд байрлаж байсан нь энэ газар ямар нэгэн суварганы тавцан байсныг илтгэх бөгөөд дээгүүр нь явахгүй бас нүдэнд ил харагдахгүй учраас ийнхүү шалны хавтан дэвсэлгүй үлдээсэн аж. Барилгын яг гол төв хэсгийн орчин тойрноос нурж унасан тоосго их хэмжээгээр гарснаас үзэхэд энэхүү хэсгийг нэлээд баг бөх хашлагаар бэхлэж байсан бололтой. Орон зайн төв дэх тоосгон өрлөгийг гол тэнхлэгийг тэмдэглэх “яасти” хэмээх бэлгэдлийн байршил хэмээн үзэж болно. Үүн дотор модон багана байсан нь ойлгомжтой боловч бодит байдал дээр ямар ч олдворын цогц хадгалагдаж үлдсэнгүй. Тиймээс голын энэхүү тулгуур баганыг шалны төвшингийн хэсгээс ямар харьцаатай суулгаж байсан тухай асуудал нээлттэй хэвээр үлдэж байна. Тэрчлэн суварганы буюу төвдийн уламжлалаар чөртэнгийн дотор талыг цацаар дүүргэж залдаг нь бүх цаг үеийн турш хэвшмэл байсан зүйл юм. Өрнөдийн ном зохиолд танил болсон жишээ бол Тангудын Хар хотын суварганууд бөгөөд түүнийг нээж олсон Пётр Козлов суваргануудыг асар олон тооны цацаар дүүргэгдсэн байсныг дурдсан байдаг.

Энэхүү олдворын цогц байдлын тайлбарыг үндэс болговол барилгын дэвсгэр зураг нь төвдөө нэгэн суварганы байгууламжтай, түүний эргэн тойронд ертөнцийн дөрвөн зүг рүү чиглэсэн хошуулдсан замуудаар дөрөв зааглагдсан бүрдэл хэсгээс бүрдэж байна. Эдгээр зам дээр бадма сэнтий байсан нь баримтаар нотлогдсон бөгөөд магадгүй хөндий гуун дотор байрлуулж байсан бололтой хоёр тодорхой олдворын цогц хадгалагдан үлджээ. Нурангин дотроос олдсон баримал дүрсийн үлдэгдлүүдийг тооцоолж үзэхэд их танхимд угтаа бүтэн биеийн хэмжээнээс харьцангуй том хэмжээтэй хөшөө баримлуудыг залж тавьсан байжээ.

Түүнээс гадна цацны бөөгнөрлийн орчмоос олон тоогоор олдсон хагас товгор гадаргуутай

бурхадын дүрсийг тэдний мутрын дохио зангаагаар нь үндсэндээ язгуурын таван бурханых гэж тогтоож болохоор байгаа юм. Тэд бурхан багшаас хувиран төрөхийн сацуу ертөнцийн зүг болгоныг эрхшээн сууж өөр өөрийн өнгө дүртэй болжээ. Тухайлбал, бясалгал үйлдэж буйг илэрхийлсэн “цаглашгүй гэрэлт” хэмээх Авид (*Amithabha*) бурхан хот мандалын баруун зүгийг эрхшээнэ, ивээл даатгалдаа авахыг илэрхийлсэн “тус буйг бүтээгч” хэмээх Амогасиди (*Amoghasiddhi*) хот мандалын хойд зүгийг эрхшээнэ, газар шороо хөндөхийг илтгэсэн “үл хөдлөгч” хэмээх Акшоби (*Akshobhya*) бурхан хот мандалын зүүн талыг, хүслийг гүйцэлдүүлэгч “эрдэнэс гарахуй” хэмээгч Ратнасамбав (*Ratnasambhava*) бурхан хот мандалын өмнөд зүгийг эрхшээдэг. Ханс-Георг Хюттелийн зааж анхааруулснаар энэхүү барилга нь Вайрочана мандалын биежсэн төлөөлөл мөн бөгөөд хот мандалын төвийг номын хүрдэн эргүүлэгч, аливаа зүйлийн учир шалтгааныг тайлбарлах “машид гийгүүлэн зохиогч” хэмээх Вайрочана (*Vairocana*) бурхан эрхшээн суудаг. Ийнхүү бясалгал үйлдэж буй язгуурын таван бурхан нь тус бүртээ өөрийн гэсэн мутрын дохио зангаагаар, зүг чигийн бэлгэдлийн онцлогтой байдаг ажээ.

Сүм байсан гэх дараагийн чухал нэгэн нотолгоо бол ертөнцийн дөрвөн зүг рүү чиглэсэн булангуудаараа мандала хэмээн танигдаж байгаа танхим нь Хархорум хотын барилгын чуулбарын ерөнхий шугамаас бараг 45° орчим хазайсан байгаа явдал юм. Хотын дийлэнхи барилга байшингууд илэрхий хойд-урд хэмээсэн чиглэлтэй байхад “Их танхим” нь энэ зарчмаас илэрхий гажсан байгаа болохыг хятадын хот суурины дэвсгэр зургийг судлах явцдаа Штайнхардт (1995) хэдийн ажиглаж “*unusual orientation*” гэж нэрлэсэн байна. Орчлон ертөнцийн тухай төсөөлөлтэй холбоотой барилгын энэхүү чиглэлийн учир шалтгааныг шашны үүднээс зүй ёсоор тайлбарлаж чадах юм.

Тэгээд ч ердийн барилгууд, түүний дотор ордон гэж үзэж байсан барилгууд ч гэсэн ерөнхийдөө хотын байгууламжийн үндсэн шугамын дагуу чиглэлтэй байдаг бол шашны барилга байгууламжуудын хувьд ертөнцийг үзэх төсөөллийнхөө дагуу зүй ёсыг чанд баримталдаг байна. Нэгэн хот доторхи ордон нь түүнийг зааг захиргааны төвийн хувьд үүнийгээ дүрслэн илэрхийлэхийн сацуу хотын үндсэн чиг шугамын энэхүү илэрхий хэлбэрээс гажих ёстой баймаар авч зөвхөн урт удаан цаг хугацааны ялгаатай тохиолдолд л ингэж барьсан байдаг, чухам яагаад ийм байсны учир шалтгааныг заах шинж тэмдэг байхгүй юм.

Анхнаасаа буддын шашны зорилгоор хэрэглэгдэж байжээ гэдгийн дараагийн нотолгоо бол барилгын үндэс суурин дээрхи найман наймын жаран дөрвөн багана хэрэглэсэн явдал буюу наймын тоог онцгой анхаарсан байдал юм. Найм бол буддын шашны хамгийн эрхэм тоо бөгөөд хятадын философид ч бас чухал үүрэг гүйцэтгэнэ.

Тэгэхлээр барилгын хэв загвар ба арга барил нь илэрхий хятадын нөлөөтэй, барилгын санаа ба үндсэн үзэл баримтлалд төвдийн нөлөө байна. Түүний зэрэгцээ өрөө тасалгааны засал чимэглэлд ч гэсэн бусад нөлөө байгааг олдсон товгор чимэглэл ба ханын зургийн үлдэгдлээс танин мэдэж болно. Ханын зургийн үлдэгдлүүдийг Бонны Их Сургуульд Ева Хоффманны одоо болтол нийтлэгдээгүй байгаа магистрын ажлын хүрээнд судлан шинжилсэн юм. Тэрбээр өөрийн судалгааны явцад Киселевын олсон ханын зураг хийгээд Монгол-Германы Хархорум Экспедицийн олсон ханын зургийн үлдэгдлүүд хоорондоо зарчмын хувьд илэрхий ялгаатай болохыг тогтоосон байна. Киселевын малтлагаас олдсон ханын зургуудыг чухам яг хаанаас олсон гэдгийг нь тодорхойлох аргагүй бөгөөд тэдгээрийн онцлог чанар, зурж дүрсэлсэн арга барилыг нь ч гэсэн тодорхой мэдэх бололцоогүй болсон ажээ. Хэв найруулгын хувьд тэдгээрийг 11–14 дүгээр зууны буддын урлагийн олон үндэстний стилийн хятад, уйгур, балба-төвдийн бүрдэл хэсгийнх хэмээн таамаглаж болох хэдий ч тодорхой уран бүтээлчийг нь тодлон тогтоох боломжгүй. Монгол-Германы Хархорум Экспедицийн илрүүлж олсон ханын зургийн үлдэгдлүүдийг Хюттель хятад-төвдийн болон 12–14 дүгээр зууны энэтхэг-балбын хэв маягтай гэж ангилсан байдаг. Үүний доторхи гойд содон зүйлс нь 20 дугаар зууны эхээр оросын эрдэмтэн Пётр Козловын нээж олсон тангудын Хар хотын олдворуудтай харьцуулан үзэхэд маш төстэй байна. Ижил төстэй байна гэдэг нь уран зураг, товойлгосон дүрслэлүүдэд нэгэн адил нотлогдсон бөгөөд Хар хотод бас буддын урлагийн ба уран барилгын арвин үлдэгдэл хадгалагдсан билээ. Ханын зургийн үлдэгдлийн зэрэгцээ 2009 онд Орхоны ойролцоо малтаж гаргасан шатаах зуухны дүүргээс олдсон хоёр галбингын толгой зэрэг шавар дүрсний хэсгүүдээс тангудын гар урлалын мэдэгдэхүйц нөлөө байхыг харж болно. 1226–1227 онд Хар хотыг эзлэн авсныхаа дараа монголчууд тангуд иргэдийг хааны ордондоо авч ирсэн байх өндөр магадлалтайг бодож үзэхэд иймэрхүү холбоо байхыг амархан ойлгож болно.

Уран барилгын салбарт төвд, монгол, хятад, бас хааяа энэтхэгийн элемент холилдон

сүлэлдсэн байх нь Монгол оронд ерөнхийдөө түгээмэл тохиолддог. Өнөө хүртэл хадгалагдсан жишээ гэвэл үнэн хэрэгтээ 16 дугаар зуунаар хязгаарлагдана. Андре Александр (2006) Монголын сүм хийдийн уламжлалт уран барилгын жагсаалт гаргахдаа гэр хэлбэрийн, модон гэр хэлбэрийн, тэг дөрвөлжин ханатай гэр хэлбэрийн, чулуу, тоосго, шавраар барьсан төвдийн нөлөө бүхий хэлбэр, хятадын уламжлалт загварын болон Манж Чин улсын хэв загварынх гэж ангилсан байна. Түүний ангилал юуны өмнө хэрэглэсэн барилгын эд материал хийгээд барилгын арга барилд төвлөрсөн бөгөөд үзэл санааны өнцгөөс авч үзэх асуудлыг анхаарлынхаа гадна үлдээжээ. Хэрэв түүний энэ шалгуураар авч үзэх юм бол Хархорумын “Их танхим” нь

хятад хэв маягаар барьсан барилга болж таарах билээ.

Төрөл бүрийн органик үлдэгдлүүдэд хийсэн ¹⁴C-ийн шинжилгээ ба термолюминесценцийн судалгааны үр дүнд гарсан байгалийн шинжлэх ухааны он цаг ихэнхдээ 13–14 дүгээр зуун гэж гарсан нь цаг хугацааны хувьд үндсэндээ түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн он цагтай яв цав нийцэж байна. Хархорумын “Их танхим” нь үүрэг зориулалт ба ашиглалтын хувьд бүхэлдээ буддын сүм байсан нь тодорхой нотлогдож байна. Хамгийн сүүлд явуулсан малтлагаар барилгын суурийн дөрвөн булангаас олдсон дарш нь энэхүү барилга 1346 оны бичээст дурдсан “Юань улсыг мандуулах асар” байсан тухай таамаглалыг улам баталгаажуулж байна.